



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар П/Н/Н/Н

Өлгий

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.1, 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлаар аймгийн нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын удирдлага, цэрэг татлагын товчооны эмч нарт сургалт, семинар явуулах, цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй шалтгаантай иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийж хугацаат цэргийн албанаас чөлөөлөх ажлыг 2019 оны 6 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулан явуулсугай.

2. Эрүүл мэндийн үзлэгээр орох иргэдийг Цэргийн штабаас хүргүүлсэн нэрсийн дагуу бүрэн хамруулахыг Цэргийн штаб /хурандаа Ц.Нацагдорж/, сумдын Засаг дарга нарт, Эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг бэлтгэх, сургалтад хамрагдах эмч сувилагч нарыг бүрэн хамруулахыг Эрүүл мэндийн газар /С.Айгүл/, Нэгдсэн эмнэлэг /Т.Серикжан/-т, даалгасугай.

3.Сургалт явуулахад шаардагдах 707000 /долоон зуун долоон мянган төгрөг/-ийг хавсралтаар баталж цэргийн мөнгөн төлбөрийн орлогоос гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Ербол/-т зөвшөөрсүгэй.

4.Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж, дүнг илтгэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Ц.Нацагдорж/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  А.ГЫЛЫМХАН



0101190993

Аймгийн Засаг даргын 2019 оны
дугаар захирамжийн хавсралт



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Зардал	Тоо /ширхэг/	Зардлын хэмжээ
1	Өдрийн хоол	15 хүн х 8000 х 2 удаа	240000
2	Завсарлага /цай кофе/	40 хүн 4 удаа	157000
3	Гарын авлага тараах материал	1550 х 200	310000
Дүн			707000

_____ оОо _____